

# Өсөлтийг чиглүүлэх нь

Европын Холбооны санхүүжилтээр бид Монгол улсын ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компани болох “Хөгжил Трейд” ХХК-д бизнесийн үйл ажиллагаагаа хамгийн үр ашигтай байдлаар зохион байгуулж, сайжруулахад нь тусалж, бараа бүтээгдэхүүний эргэлтийг нь 84 хувиар нэмэгдүүлсэн.



# Монгол улсын ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компани

Бид Монгол улсын ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компани болох “Хөгжил Трейд” ХХК-д бизнесийн үйл ажиллагаагаа хамгийн үр ашигтай байдлаар зохион байгуулж, сайжруулахад нь тусалж, бараа бүтээгдэхүүний эргэлтийг нь 84 хувиар нэмэгдүүлсэн.

1992 онд байгуулагдсан “Хөгжил Трейд” ХХК нь Ариун Брэндийн нойтон салфетка, ариун цэврийн цаас, рестораны зориулалттай төрөл бүрийн хуурай салфетка зэрэг 40 гаруй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч үндэсний компани юм. Ялангуяа, Ариун нойтон салфетка нь үндэсний стандартыг хангаж, баталгаажсан патенттай бүтээгдэхүүн болсон юм. 54 ажилтантай тус компани нь бүтээгдэхүүнээ дотоодын зах зээл дээр борлуулдаг бөгөөд дотоодын зах зээлийн 20 хувийг эзэлж, Kleenex, Selpak болон Zewa зэрэг дэлхийн хэмжээний топ компаниудын импортлолсон бүтээгдэхүүнтэй өрсөлддөг.



“Хөгжил Трейд” ХХК нь Монгол улсын ахуйн хэрэглээний үйлдвэрлэлийн компани бөгөөд “Ариун” брэндийн нойтон салфетка, ариун цэврийн цаас, рестораны зориулалттай төрөл бүрийн хуурай салфетка зэрэг 40 гаруй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг.

Өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхийн тулд тус компани бизнесийн үйл ажиллагаагаа дахин зохион байгуулах замаар дотоодын зах зээлд эзлэх хэмжээгээ хадгалж, өргөжүүлэх шаардлагатай байсан. Компанид тулгарч байсан нэгэн том бэрхшээл нь зохион байгуулалтын тодорхой бус бүтэц, үр дүн муутай үйлдвэрлэлийн үйл явцаас шалтгаалсан бүтээмж доогуур, цагийн менежмент муу байсан явдал байсан.

Бид “Хөгжил Трейд” компанийг Японы менежментийн аргачлал болох 5S –д тулгуурлаж, бизнесийн үйл ажиллагаагаа сайжруулахад нь тусалсан дотоодын зөвлөх Коннект ХХК-тэй холбож өгсөн. Тус зөвлөх нь :

- Компанийн нөхцөл байдлыг судалж, шинжилсэн
- Компанийн хэрэгцээнд тулгуурлан 5S аргачлалын тогтолцоог боловсруулж, тохируулсан
- Хүний нөөцийн тогтолцоог шинэчлэн өөрчилсөн
- Шинэ бизнесийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар компанийн менежмент болон ажилчдад сургалт хийж, зааж өгсөн.

Төсөл хэрэгжиж дууссанаас хойш нэг жилийн дараа тус компани борлуулалтын орлого хэмжээг 84 хувиар, хөдөлмөрийн бүтээмжийг 42 хувиар нэмэгдүүлж үйл ажиллагааны зардлыг 7 хувиар бууруулж чадсан. “Хөгжил Трейд” компани ариун цэврийн цаас, нойтон салфетка, хуурай салфетка зэрэг шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлж, Өмнөговь аймагт шинэ үйлдвэр байгуулсан.

[www.ebrd.com/knowhow](http://www.ebrd.com/knowhow)

Борлуулалтын орлого

**+84%**

Хөдөлмөрийн бүтээмж

**+42%**

Нэг ажилчны бий болгож байгаа ашиг

**+125%**

Төслийн нийт зардал

**15,260 Евро**

Харилцагчын хуваалцсан зардал

**50%**